Авлигатай тэмцэх газрын 2025 оны "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй		1	0.8	80
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх		1	0.5	50
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	100
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	100
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	100
Хэсгийн оноо				4	2.8	70
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр		1	1	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг		1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг		1	1	100
Хэсгийн оноо				3	3	100
7	Ёс зүйн дэд хорооны манлайлал	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн		1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг		1	1	100
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх		1	1	100
Хэсгийн оноо				**3**	**3**	100
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.8**	**88**

Авлигатай тэмцэх газрын 2025 оны ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан

НЭГ. Товч танилцуулга
Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг холбогдох хуулиас гадна АТГ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм, АТГ-ын албан хаагчийн сахилгын дүрэм, АТГ-ын Хөдөлмөрийн дотоод журам зэрэг баримт бичгүүдийг үндэслэн хэрэгжүүлж байна.
Албан хаагчийн гаргасан зөрчлийг АБХШНА болон Ёс зүйн дэд хороо харьяалан шалгаж, шийдвэрлэдэг бөгөөд 2025 оны байдлаар Ёс зүйн дэд хороонд хандан гаргасан өргөдөл, гомдол байхгүй байна.
Холбогдох хууль, дүрэм, журмын өөрчлөлттэй холбоотой болон баримт бичгүүдэд тусгагдсан сургалтуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, албан хаагчдын цахим хаягаар тухай бүр холбогдох зөвлөмж, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд мөрдөгддөг дүрэм журам, бодлогын баримт бичгүүдэд албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг тусган хэрэгжүүлж байна.
Байгууллагын дотоод болон бусад төрийн байгууллагуудад албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр холбогдох сургалтуудыг зохион байгуулсан.
Шинээр албан хаагч томилохдоо аливаа сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, ял шийтгэлгүй албан хаагчдыг сонгон шалгаруулж томилсон.
Албан хаагчдыг ёс зүйн зөрчил, дутагдал гаргуулахгүй байх зорилгоор дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулж, цахим программуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
ТАЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хороо зэрэг нийт 57 байгууллагатай хамтран төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийт 193 контент болон богино хэмжээтэй Reel видеог бүтээж дээрх байгууллагуудын цахим хуудас, Авлигатай тэмцэх газрын “Олон нийтийн төв” пейж хуудас болон бусад пейж хуудсаар олон нийтэд түгээсэн.
Боловсролын ерөнхий газрын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний газартай хамтран мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн хөтөлбөрт ёс зүйн агуулга тусгасан байдлын талаарх судалгаа хийж, үр дүнгийн талаар Насан туршийн боловсролын хэлтэс, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний газар, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн иргэний ёс зүйн боловсрол, нийгэм судлалын болон мэргэжлийн багш нар, сургалтын арга зүйч нийт 45 оролцогчийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.
Авлигын эсрэг хуулийн 6.1.9 дэх хэсэгт “Төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах” гэж заасны дагуу нийт 11 байгууллагын ёс зүйн дүрмийн төсөлд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг тусгах, авлигаас ангид, шударга байх хэм хэмжээг тусгах талаарх холбогдох саналыг хүргүүлсэн.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Дараах баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээг төлөвлөгөөний дагуу албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
"Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм" нь албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд чиглэгдсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/106 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан.

"Авлигатай тэмцэх газрын Хүний нөөцийн төлөвлөлтийн баримт бичиг"-ийн 2.12-т Ёс зүйн үнэт зүйлийн хэмшүүлэлт: Албан хаагчдаас сахилга, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн байдлыг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулахад харгалзан үзэх нөхцөл болгоно. Төрийн албан хаагчийн ёс зүй харилцааны ур чадвар, сэтгэл зүй, удирдлагын сэтгэл зүйн чиглэлээр албан хаагчдыг сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

"Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-т шинээр томилогдсон албан хаагчийн сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулахаар тусгасан. Мөн тус хөтөлбөрийн агуулгын 50 хүртэл хувь нь шинэ мэдлэг чадвар эзэмшүүлэхэд чиглэх ба хууль эрх зүй, сэтгэл судлал, ёс зүй, дүн шинжилгээ зэрэг сэдвүүдийг агуулсан байхаар тусгасан.

"Авлигатай тэмцэх газрын аюулгүй байдлыг хангах журам"-д албан хаагчийн сахилга, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалган тогтоож, үнэлэлт дүнэлт өгч, авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор эрх бүхий албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцүүлэн албаны шалгалт хийнэ.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр шинэчлэн байгуулсан. Тус хорооны үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж байна.

Дэд хороонд хандан ирүүлсэн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл байхгүй.

Авлигатай тэмцэх газар нь албан хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой шалгалтын тайлан, бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэлжүүлэх ажилладаг.

Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга болон Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаар тушаалын хавсралтаар батлсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 9.2-т заасны дагуу холбогдох тушаалын хуулбарыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлдэг.

Холбогдох хууль, дүрэм, журмын өөрчлөлттэй холбоотой болон баримт бичгүүдэд тусгагдсан сургалтуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, албан хаагчдын цахим хаягаар тухай бүр холбогдох зөвлөмж, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн бусад байгууллагаас зохион байгуулсан “Ёс зүй, Хүний эрх” зэрэг сургалтуудад холбогдох албан хаагчдыг хамруулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:

Албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй. Албан хаагчдын хариуцлага улам бүр нэмэгдсээр байна.

Бэрхшээл:

-

Санал:

-

БАТЛАВ
ГАЗРЫН ДЭД БӨГӨӨД
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР
Г.АЗЖАРГАЛ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах нэгж
1	2	3	4	5
Нэг. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд				
1	Албан хаагчдад зориулсан ёс зүйн танхимын болон цахим сургалт, арга хэмжээг зохион байгуулах	Улирал тутам	Нийт албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.	Ёс зүйн дэд хороо, Тамгын хэлтэс
2	Шинээр томилогдсон албан хаагчдад ёс зүйн хууль тогтоомжийг танилцуулах, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Шинээр томилогдсон албан хаагч бүрт нэг удаа зөвлөмж өгсөн байна.	Ёс зүйн дэд хороо, Тамгын хэлтэс
3	Төрийн бусад байгууллагуудаас зохион байгуулж буй зүйн сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулах	Тухай бүр	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байна	Ёс зүйн дэд хороо, Тамгын хэлтэс
4	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд мөрдөгддөг дүрэм журам, бодлогын баримт бичгүүдэд албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг тусган хэрэгжүүлэх	Жилдээ	Бодлогын баримт бичгүүдэд албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг тусган мөрдөж эхэлсэн байна.	Ёс зүйн дэд хороо, Тамгын хэлтэс
5	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах, цахим программуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.	Жилдээ	Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа сайжирч, цахим програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	Ёс зүйн дэд хороо, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба

1	2	3	4	5
6	Төрийн бусад байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий контент болон богино хэмжээтэй Reel видеог хийж түгээх	Жилдээ	Контент болон богино хэмжээтэй Reel видеог хийж түгээсэн байна.	Ёс зүйн дэд хороо, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс
Хоёр. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгах, шийдвэрлэх зорилтын хүрээнд				
1	Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах	Тухай бүр		Ёс зүйн дэд хороо
Гурав. Дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг тогтворжуулах зорилтын хүрээнд				
1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлах, хэрэгжүүлэх	1 дүгээр улиралд	Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.	Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн дэд хороог хуралдуулах	Тухай бүр	Хурал зохион байгуулсан байна.	Ёс зүйн дэд хороо
3	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр сургалтад хамруулах	Тухай бүр	Сургалтад хамрагдсан байна.	Ёс зүйн дэд хороо
4	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх, баримт бичгийн бүрдлийг ханган архивт хүлээлгэн өгөх	4-р улиралд	Тайлан хүргүүлж, баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байна.	Ёс зүйн дэд хороо

ХЯНАСАН:
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР З.БААСАННЯМ

БОЛОВСРУУЛСАН:
ТАМГЫН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦ,
СУРГАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН, КОМИССАР Р.ЭНХ-АМГАЛАН